



БАТЛАВ.



ЗАХИРАЛ.

**СОЁЛ УРЛАГИЙН ИХ СУРГУУЛИЙН БАДМААРАГ АХЛАХ СУРГУУЛИЙН БҮЖГИЙН 112, 118 ТООТ ЗААЛНЫ ШАЛ ЗАСВАРЛАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

Дугаар № ТХ-06/2017

2017 оны 08 сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг талаас /"Соёл урлагийн их сургуулийн Бадмаараг ахлах сургууль"/ (цаашид захиалагч" гэх), нөгөө талаас /"АВВКНСТ" ХХК / (цаашид "гүйцэтгэгч" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2017оны 08 сарын 07-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь /Соёл урлагийн их сургуулийн Бадмаараг ахлах сургуулийн бүжгийн 112, 118 тоот заалны шал засварлах ажил гүйцэтгэх гэрээ Дугаар № ТХ-06/2017/ (цаашид "ажил" гэх) /35,517,957 гучин таван сая таван зуун арван долоон мянга есөн зуун тавин долоон төгрөг/ (цаашид "гэрээний үнэ" гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн /35,517,957 төгрөг/ /гучин таван сая таван зуун арван долоон мянга есөн зуун /төгрөгийг СУИС-ийн Бадмаараг ахлах сургуулийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

Шалны засварын ажлын зардал	34,096,087
Захиалагчийн албаны зардал	683,038
Инженер, хайгуул, зураг төслийн ажлын зардал	0
Магадлашгүй ажлын зардал	683,038
Норм нормативын	55,794

4. Гүйцэтгэгч нь УБ Чингэлтэй дүүрэг 4 хороонд байршилтай СУИС-ийн Бадмаараг ахлах сургуулийн бүжгийн 112, 188 тоот заалны шалны засварын ажлыг техникийн тодорхойлолтын дагуу хийж гүйцэтгэнэ. Ажлыг 2017 оны 08 сарын 08-ний өдөр эхэлж 2017 оны 08 сарын 23-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Санхүүжилтийн хуваарь;
- 5.9. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ. Үүнд: Төсвийн 40 хувийг урьдчилгаанд, ажлын гүйцэтгэлээр үлдэгдэл төлбөр тооцно.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичиг, цахим шуудан болон утсан холбоогоор харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[СУИС-Бадмаараг сургуулийн захирал]

[“АВВКНСТ” ХХК захирал]

[В.Бүрэнжаргал] *В. Бүрэнжаргал*

[Л.Бямбадорж]

ТАМГА

ТАМГА

[УБ хот ЧД 4-р хороо СУИС-ийн

[УБ хот БЗД 1-р хороо Гөдөншил 103-104 тоот

хичээлийн 3-р байр]

[Утас: 9999-7457, 9551-1033]

[Утас: 7012-3389, 7013-3389]